

ШИНЭ ҮЕ ШАТАНД ШИЛЖСЭН ЯПОН, ХЯТАДЫН ХАРИЛЦАА БА ЗҮҮН АЗИ

*Моори Казүко**

1. Япон, Хятадын харилцааны 4 үе шат

Хоёр орны хооронд дипломат харилцаа сэргээснээс хойш өдгөөг хүртэл 30 гаруй жилийг ардаа үдэж байгаа Япон, Хятадын харилцааны хөгжлийн үйл явцыг түүний бүтэц агуулгын өөрчлөлтөөс хамаарч дараах 4 үе шатанд хувааж болно.

1-рт 1970-аад оны үе, 2-рт 1980-аад оноос 1990-ээд оны дунд үе, 3-рт 1990-ээд оны сүүлийн хагасаас 2005 он хүртэл, 4-рт 2005 оны хавар Хятадад болсон Японы эсрэг жагсаалаас өнөөдрийг хүртэл гэж хувааж болно. 2005 оны хавар Хятадад болсон “Японы эсрэг жагсаал” болон түүнийг тойрсон асуудлуудаас үүдэн Япон, Хятадын харилцаа хурцадсан явдал хоёр орны харилцаа 4 дэх үе шатандаа буюу шинэ үе шатанд шилжсэнийг харуулав.

1970-аад оны хоёр орны харилцаанд үндсэндээ “найрамдалт харилцаа” давамгайлсан гэж хэлж болно. Гэрэлтэй болон бараан тал хосолж байсан боловч хоёр тал энэхүү шинэ харилцаандаа битүүхэн найдвар тавьж байлаа.

Хятад улс шинэчлэл, нээлттэй бодлого явуулж эхэлсэн 80-аад онд Хятадын тэрхүү шинэчлэлийг дэмжих нь Японы бодлогын үндсэн чиглэл байсан бөгөөд Хятад улс ч тэр дэмжлэгт ихээхэн найдвар тавив. Эдийн засгийн асуудлуудыг тойрсон маргаан, түүхийн сурах бичгийн асуудал зэрэг зөрчилдөөнүүд гарч байсан хэдий ч АНУ, Япон хоёр “Хүчтэй тогтворжсон Хятад улс” бий болохыг хүсч байсан ба зүйрлэж хэлбэл Япон, Америк, Хятад гурван улсын харилцаанд энэ үе “хуримын бал сар” мэт хамгийн нөхөрсөг дотно үе байсан гэж хэлж болно.

Япон, Хятадын хоёр талын харилцаанд бий болсон “тусалж буй орон, тусламж авч буй орон” гэсэн харилцааны хэлбэрийг хоёр тал харилцан хүлээн зөвшөөрч байсан төдийгүй тэр нь Японы эдийн засгийн өсөлтөд ч сайнаар нөлөөлөв.

Гэтэл 1995-1996 оны үеэс эхлэн хоёр орны харилцаанд өөрчлөлт гарч эхлэв. Хятадын макро эдийн засгийн огцом өсөлт нь эдийн засгийн зогсонги байдал үргэлжилсэн Японы нэг хэсэг хүмүүст “Өрсөлдөгч Хятад” гэсэн шинэ ойлголтыг төрүүлсэн бөгөөд Тайваний Ерөнхийлөгчийн сонгуульд дарамт үзүүлэхийн тулд Хятад улс Тайваний хоолойд пуужингийн сургуулилт хүчээр явуулсан нь “Хятадын аюулын онол”-ыг бий болгов.

* Моори Казүко - Японы Васэда Их сургуулийн Улс төр, Эдийн засгийн сургуулийн профессор

Нөгөө талаар хүйтэн дайны дараагаар Азид үүссэн олон улсын нөхцөл байдалд зохицохын тулд Япон ч гэсэн шинэ бодлого боловсруулж, 1995-1996 онд Япон-Америкийн Аюулгүй байдлын гэрээг “шинэчлэн тодорхойлсон” нь Хятадын болгоомжлолыг улам нэмэгдүүлэв.

Улмаар 1990-ээд оны дунд үеэс Япон, Хятадын харилцаа шинэ үе шатанд шилжив. Шинэ үе шат гэж нэрлэж байгаагийн учир нь нэгдүгээрт, эдийн засгийн хувьд харилцан биенийгээ нөхөх, хоёрдугаарт, улс төрийн талаар харилцан өрсөлдөх харилцаанд шилжиж, цаашлаад хоёр орны харилцаа нь засгийн газар хоорондын төдийгүй иргэд хоорондын харилцааны түвшинд өргөжин хөгжсөнтэй холбоотой юм.

Цаашид хоёр орны хооронд янз бүрийн маргаан, зөрчил мөргөлдөөн гарах магадлал өндөр гэж хэлж болно. Учир нь түүний цаана өдрөөс өдөрт томорсоор буй Хятадтай хэрхэн харьцах аргаа олохгүй байгаа Японы “сандрал” байгаа юм.

Японы байр сууринаас харахад Хятад нь Японы өрсөлдөгч үү, эсвэл түнш үү, түүнчлэн Япон улс Азид ямар бодлого баримтлах нь зохистой вэ? зэрэг асуултуудад хариу олдохгүй хэвээр байна. Нөгөө талаар Хятадын хувьд цэргийн хүчээ зузаатган, Иракийн сэргээн босголтод Японы өөрийгөө хамгаалах хүчнийг илгээх зэргээр аюулгүй байдлын олон улсын салбарт хувь нэмрээ оруулахыг чармайж буй Японтой хэрхэн харьцах нь мөн л тодорхой бус байгаа бөгөөд тэрхүү бодлогоо боловсруулах шатандаа байна.

2. Эдийн засгийн харилцан нөхөлт ба олон нийтийн үзэл бодол


Дээр өгүүлсэнчлэн хоёр орны хооронд хэрхэн харьцах аргаа олохгүй сандралд автах эсвэл тэр бодлого нь тодорхойгүй байгаа зэрэг олон асуудлууд байгаа боловч эдийн засгийн хувьд хоёр орны “харилцан хамаарал” хүссэн хүсээгүй гүнзгийрсээр байна. Илтгэгч миний үзэхэд “харилцан хамаарал”-ын хэмжээнээс давж “харилцан биенийгээ нөхөх” шатанд өнөөдөр хүрсэн гэж хэлж болно.

Гадаад худалдааны үзүүлэлтүүдээс тэдгээр нь тодорхой харагдаж байна. Тухайлбал, 2003 онд Японоос Хятадад гаргасан экспортын хэмжээ 6 триллион 60 сая иен, импортын хэмжээ нь 8 триллион 70 сая иенд хүрсэн байна. Экспортын хэмжээ нь өмнөх оныхтой харьцуулахад 33 хувиар, импорт 13 хувиар нэмэгджээ. Японы гадаад худалдааны нийт эргэлтэд Хятадын эзлэх жин экспортод 12.2 хувь буюу дэлхийд хоёрдугаар байр, импортод 19.7 хувь буюу дэлхийд нэгдүгээр байрт орж байна. /Диаграмм 1-д Японы Америк болон Хятадтай хийсэн худалдааны үзүүлэлтийн өөрчлөлтийг харьцуулан үзүүлэв./

Хятадаас оруулсан импортын хэмжээ нь аль 2002 онд Америкийн импортын хэмжээг давж, экспортыг оролцуулан худалдааны нийт хэмжээгээрээ Хятад улс Японы хамгийн том худалдааны түнш болох цаг удахгүй ирэх нь тодорхой боллоо.

Ийнхүү Японы эдийн засаг Хятадаас хамааралтай болж байгаа нь эсрэгээр авч үзвэл Хятадын эдийн засаг ч мөн адил Японоос хамааралтай болохыг харуулж байна. Аль нэг нь эдийн засгийн зогсонги байдалд орвол нөгөөдөө том цохилт болохуйц “харилцан биенийгээ нөхсөн” байдал улам бүр гүнзгийрсээр байна.

Энэхүү “Харилцан биенийгээ нөхсөн” байдал нь SARS буюу Азийн ханиад, шувууны өвчин, байгаль орчин зэрэг “хүний аюулгүй байдалтай” шууд холбоотой байгаа нь түүний эмзэг шинж чанарыг харуулж байна. Эдийн засгийн харилцаа болон ямар нэг вирусд өнөөдөр хил хязгаар гэж байхгүй. Тийм болохоор бид Япон, Хятадын харилцааг өрсөлдөгч, аль эсвэл түнш гэж өөрсдийн сайн дураар аль нэгийг нь сонгох цаг үе нэгэнт өнгөрчээ.



Хоёр орны харилцаа иргэд хоорондын түвшинд өргөжсөнийг 2003 оны намар Хятадын Сибэйи их сургуульд болсон үйл явдал тодорхой харуулж байна. Тус сургуульд сурч байсан нэгэн япон оюутан бүдүүлэг авир гаргасныг “доромжлол” гэж хүлээж авсан хятад оюутнууд шуугиан дэгдээсэн нь тэр сургуулийн нийт япон оюутнуудыг дайрч довтлоход хүргэсэн билээ. Ялимгүй нэг сэтгэлийн хөдлөлөөс болсон зөрчилдөөн нь даамжирч хоёр орны хооронд мөргөлдөөнд хүргэж болох аюул хоёр орны харилцаанд урьдаас оршоор ирсэн.

Түүний цаад шалтгаан нь өнгөрсөн түүхийн үнэний тухай төдийгүй түүнийг өнөөдөр хэрхэн ойлгох ёстой талаар хоёр тал маргаж буй “түүхийн асуудал”-тай холбоотой бөгөөд тэр нь энэ мэт ялимгүй маргааныг сэтгэл хөдлөлөөр хөөрөгдөн улмаар үндэсний үзэл болгон хувиргаж байгаад оршино.

1990-ээд он гарсаар Хятадыг үзэх Японы үзэл маш ихээр өөрчлөгдсөнийг харуулах нэгэн баримтыг дурдъя. 1978 оноос “эхлэн засгийн газрын хэрэг эрхлэх газраас жил бүрийн 10 сард “Гадаад бодлогын талаарх олон нийтийн санал асуулга”-ыг 3000 хүний дунд явуулж ирсэн юм. 1988 он хүртэл уг санал асуулганд оролцсон хүний

70 орчим хувь нь “Хятад улс дотно санагддаг”, “Япон, Хятадын харилцааг сайн байгаа гэж үздэг” хэмээн хариулж байсан бол тус үзүүлэлт нь Тяньмэний талбайд болсон хэрэг явдлаас хойш нэгэн зэрэг 20 орчим хувиар буурч, 1996 онд Тайваний хоолойд болсон хямралаас үүдэн “Хятад улс дотно санагддаг” гэж хариулж байсан хүний эзлэх хувь 45 хувь, “Япон, Хятадын харилцааг сайн байгаа гэж үздэг” хэмээн хариулж байсан хүний тоо 36 хувь болтлоо буурчээ. Түүнээс хойш дээрх үзүүлэлтүүд бага зэрэг дээшилсэн хэдий ч 1988 оны өмнөх үзүүлэлтүүдэд хүрээгүй бөгөөд өдгөө 40 гаруй хувьтай байна.

Судалгаанд хамрагсдын бараг тал хувь нь “Хятад улс дотно санагддаг” гэж үзэж буй нь сайшаалтай хэрэг мөн боловч 90-ээд оноос хойш Хятадын талаарх иргэдийн үзэл бодол үндсээрээ өөрчлөгдсөн нь тодорхой харагдаж байна. (Дээрх судалгааны талаар засгийн газрын хэрэг эрхлэх газрын “Гадаад харилцааны талаарх олон нийтийн санал асуулга” <http://www8.cao.go.jp/survey/h15/h15-gaikou/-web> хуудаснаас үзнэ үү).

Бас нэгэн судалгааны баримт бол 2002 оны 8-9 сард “Асахи шимбун” буюу Японы Асахи сонины газар Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнтэй хамтарч явуулсан санал асуулга юм. Энэ судалгаанд 2000 орчим хүн оролцсоны талаас дээш хувь нь Хятадыг “өрсөлдөгч” гэж үздэгээ илэрхийлсэн бөгөөд энэ үзүүлэлт дээр “10 жилийн дараагаар бодит аюулын хүчин зүйл болно” гэж хариулсан хүний хувийг нэмвэл 65 орчим хувь болж байна. Гэтэл Японы талаарх Хятадын ийм үзүүлэлт буурах хандлагатай байгаа нь сонирхол татаж байна. Мөн Хятадуудын дунд Японд “дургүй” гэж хариулсан хүний тоо өсч, талаас илүү хувь нь “дургүй” гэж хариулсан нь анхаарал татаж байна.

Улмаар “Цэрэг зэвсгийн талаар аюултай гэж үзэж буй орон”-д хятадуудын 60 хувь нь Америкийг нэрлэсэн байхад Японы талаар харин ч багасах хандлагатай байна. Мөн Япончуудын тэн хагас орчим нь “Хойд Солонгос”-ыг нэрлэж, 20 хувь нь Америкийг нэрлэсэн байна. (“Асахи шимбун” /Асахи сонин/, 2002 оны 9-р сарын 27-ны өдрийн дугаар).

Дээрх судалгааны баримтуудаас үзэхэд Хятадын олон нийтийн үзэл бодол олон хэв маягтай болон өөрчлөгдөхийн зэрэгцээ сэтгэл хөдлөлийн шинжтэй байгааг харуулж байна. Урьд өмнө нь Японтой харьцах харилцааг Хятадын коммунист нам болон Төв Засгийн газар дангаар зохицуулж ирсэн бол одоо олон хэв маяг, сэтгэл хөдлөлийн шинжтэй болсон олон нийтийн үзэл бодлыг сайтар бодолцох шаардлагатай болсоныг дээрх судалгаа харуулж байна.

Өмнөд Солонгосын жишээ тодорхой харуулж байгаачлан иргэд хоорондын өдөр тутмын соёлын харилцаа холбооноос сэтгэл санааны хувьд харилцан ойлголцолд хүрч чадаж байгаа нь Япон, Хятадын харилцаанд ч гэсэн ихээхэн утга агуулгатай байж болох юм. Олон

нийтийн үзэл бодол хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон улсын болон хоёр орны харилцаанд чухал үүрэг гүйцэтгэх болсон нь Япон Хятадын харилцаа ч сэтгэл хөдлөлийн шинж чанартай болоход нөлөөлж байна. Хэдий тийм боловч олон нийтийн үзэл санааг хянах боломжгүй бөгөөд тэр нь хэрхэвч зөв бодлого биш юм.

3. Зогсонги үзэл бодлоос шинэ үзэл бодол руу

Дээр дурдсан нөхцөл байдлын дундуур 2002 оны сүүлчээс эхлэн нэг жилийн турш Хятадын төрөл бүрийн үзэл бодлын индэр, интернет, хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Японы талаарх шинэ үзэл бодол”-ын талаар ширүүн маргаан өрнөв. Тэрхүү шинэ үзэл бодлын агуулга нь “Өнгөрсөн түүхийн асуудлыг хойш тавьж, Японыг стратегийн талаар чухалчилж үзэх хэрэгтэй” гэсэн санааг агуулсан бөгөөд үүнийг Хятадын нэгэн судлаач дэвшүүлэн тавьсан юм. Түүний энэ саналын талаар Хятадын олон нийтийн дунд ширүүн маргаан дэгдсэн бөгөөд дайнаас хойш Японтой харьцах харилцааны талаар анх удаа чөлөөт маргаан өрнөсөн нь энэ юм.

Олон нийтийн үзэл бодол “Зөв гэж үзэж байна”, “Хэрхэвч зөвшөөрөхгүй”, “Аль аль нь туйлшрал” гэх зэргээр хоёроос гурван хэсэгт хуваагдав. Хятадын талаар харьцангуй хатуу байр суурь баримталдаг Японы “Санкэй шимбун”/Санкэй сонин/ болон “Ёмиури шимбун” /Ёмиури сонин/ зэрэг зарим нэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд “Японы талаар дотно байр суурь баримтлагчид” шинээр гарч ирсэнд талархан хүлээж авлаа.

Хоёр орны харилцааг эргэж харваас өнөөг хүртэл удаан хугацаанд Япон, Хятад аль алинд нь үзэл бодлын зогсонги байдал үргэлжилж ирсэн гэж хэлж болно. Тухайлбал Япон улс Япон-Америкийн харилцаанд тулгуурласан эдийн засгийн хөгжлийг хөгжлийн үндсэн зарчмаа болгон 50 орчим жил баримталж ирэхдээ ямар нэг байдлаар шүүмжлэлтэй хандаж байгаагүй бөгөөд Хятадтай харьцах харилцаа нь энэ хүрээн дотор багтаж байсан тэр үед ямар нэг асуудал үүсээгүй билээ.

Нөгөө талаар Хятадын талаас Японтой харьцахдаа “Түүхийн асуудал” хэмээх хүчтэй хөзрийг ашиглаж ирсэн бөгөөд тэр хөзөр нь хүчинтэй байсан тохиолдолд Японтой харьцах харилцааг үргэлж өөртөө ашигтайгаар зохицуулж болно гэж үзсэн “стратегийн үзэл бодол” үргэлж ноёрхож ирэв. Энэхүү хэвийн бус “үзэл бодлын зогсонги байдал” нь Хятадад ялимгүй боловч өөрчлөгдөж эхэлсэн юм.

Олон улсын улс төр судлаач Ши Иньхан /Shi Yinong/ “Японы талаарх шинэ үзэл бодол”-доо “Хоёр орны ард түмний хооронд бие биеэ үзэн ядах, дайсанган үзэх явдал ихэсч байгаа болон Японы зарим нэг хүмүүсийн гаргаж байгаа Хятадын эсрэг хэт туйлширсан үндсэрхэг үзэлд сэтгэл зовниж байна. Энэ байдал цаашид үргэлжилбэл Хятад улс дайсангасан Америк, Тайвань, Энэтхэг дээр нэмэгдээд “Дайсангасан Япон”-

той харьцахад хүрнэ. Тиймээс “Нэгдмэл үзэл бодлоос гараагаа эхэлж, стратегийн үндсэн өөр агуулгад тулгуурлан Хятад, Японы харилцааг өөрчлөн сайжруулах, хоёр орны ойртон нягтралыг бодитойгоор хэрэгжүүлбэл, удаан хугацааны аюулгүй байдлын хувьд Америкаас Хятадад үзүүлж буй бодит болон нуугдмал аюул, дарамт шахалтад хариулт өгөөд зогсохгүй Тайваний тусгаар тогтнолоос урьдчилан сэргийлэх зэрэг тулгамдсан чухал асуудлуудад хүчээ төвлөрүүлж чадна” гэжээ. Тэрбээр энэ үзлээ “Гадаад бодлогын хувьсгал” (rapprochement) гэж нэрлээд, 1971-1972 оны Америк, Хятадын харилцааны ойртолтыг баримт болгон тавьжээ. Мөн тэрээр Япон улс их хэмжээгээр ухралт хийгээгүй тохиолдолд түүхийн асуудлыг гадаад бодлогын хэлэлцэх асуудлаас хасах, Солонгосын хойг болон Зүүн Өмнөд Азийн орнуудтай чөлөөт худалдааны гэрээ /ФТА/ байгуулах, Зүүн Азийн аюулгүй байдал улс төрийн хамтын ажиллагааны салбарт их гүрэн болж оролцохыг хүлээн зөвшөөрөх, Япон улсыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болоход нь идэвхтэй дэмжлэг үзүүлэх, Японоос Хятадад оруулж буй хөрөнгө оруулалтыг дэмжих, Хятадад эдийн засгийн тусламж үзүүлж ирсэнд талархал илэрхийлэх зэрэг тодорхой саналуудыг дэвшүүлжээ. (Shi Yinhong. Хятад-Японы ойртолт буюу “Дипломат бодлогын хувьсгал”. Хятадын Ардын их сургуулийн Олон улсын харилцааны хүрээлэн “Стратегийн удирдлага” сэтгүүл. 2003 оны дугаар 2)

Дээр дурьдсан Ши Иньханы “Зардал гаргахгүй гадаад бодлогын хувьсгал”-ын онол нь ихээхэн дуулиан дэгдээсэн боловч Хятадын ихэнх Япон судлаачид түүнийг эрс шүүмжлэв. Тэдний нэг болох Jin Xide (Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн Япон судлалын газар) юм. Тэрээр 1-рт Япон, Хятадын харилцаа ээдрээтэй байгаагийн шалтгааныг Хятадын талд бий гэж үзэж байгаа Шигийн ойлголт нь үндсээрээ буруу, 2-рт Хятад улс аль 90-ээд оны сүүлчээс Японыг анхаарах бодлогод шилжсэн бөгөөд Японы талаас шинэ үзэл бодол гаргаагүй цагт Японтой одоогийнхоос илүү ойртох нь зүй зохист нийцэхгүй, 3-рт Америкийг хазаарлан барихын тулд Японтой ойртоно гэдэг нь яагаад ч бодит байдалд нийцэхгүй хэмээн хатуу шүүмжилжээ. Улмаар тэр Японоос Хятадын талаар явуулж байгаа бодлогыг “Стратегийн ядуурал”, “Салхины аясыг даган урсаж байна” хэмээн давхар шүүмжилсэн байна. Өөрөөр хэлбэл тэрээр Япон, Хятадын харилцаанд саад тогтор болж байгаа хүчин зүйлийн ихэнх нь Японы талд буй гэж үзсэн байна. /Jin Xide (Япон судлалын газар), Жэнминь жибао /Ардын өдрийн сонин/ сонины шүүмжлэгч” Япон, Хятадын “шинэ үзэл бодол” гэж юу вэ?/, Ши Иньхан нарын өгүүллийн шүүмж” 2003 он/

Илтгэгч намайг хамгийн их цочролд оруулсан нь Японтой түүхийн он удаан жилийн харилцаатай Нанькайгийн Их сургуулийн Олон улсын асуудал судлалын Хүрээлэнгийн захирал Zhang Yingzhuang-ийн бичсэн

өгүүлэл байлаа. Тэрээр Шигийн үзэл бодлыг “Хэзээ ч байж болшгүй алдаатай үзэл” гэж үндсээр нь шүүмжилжээ. Японтой “сэтгэл хөдлөлөөр” харьцахад юу нь буруу юм бэ? 35 сая хүн дайны хохирол амссан байтал Хятадын эсэргүүцэл еврейчүүдтэй харьцуулахад харин ч бага, дайны гамшигт харамсан суусаар байх ёстой гэж үү? хэмээн буруутгажээ.

Мөн тэрээр Шигийн дэвшүүлсэн үзлийг дараахь байдлаар шүүмжилжээ. 1-рт олон улсын харилцаан дахь улс хоорондын байр суурь, хүчний харьцаа гэдэг бол хоёр талын авсан оноо нь үргэлжийн тэнцүү байдаг тоглоом (zero-sum game)-той адил бөгөөд ялангуяа геополитикийн өрсөлдөөнт харилцаанд байгаа Япон, Хятадын харилцаа бол тийм хэлбэртэй байх ёстой, 2-рт түүхийн асуудлыг Японтой хийх хэлэлцээний сэдэв эс болговоос олон улсын тавцан дахь хүч нөлөөгөө алдахад хүрэх бөгөөд олон улсын тавцан дахь Хятадын хүч нөлөө бол хамгийн чухал, тодорхой хэлбэргүй стратегийн том баялаг мөн” гэх мэтээр тодорхой шүүмжилжээ. (Zhang Yingzhuang. Японы талаарх шинэ үзэл бодолд Хятадын үндэсний онцлог болон дипломат бодлогын гүн ухааныг тусгах нь. “Дэлхийн эдийн засаг, улс тэр” сэтгүүл, 2003 он №12, 25-30-р хуудас).

2003 онд явагдсан “Японы талаарх шинэ үзэл бодол”-ын тухай дээрх маргаан нь юутай ч гэсэн өнөөг хүртэл хаалттай байсан Японы тухай үзэл бодол маргааныг чөлөөтэй болгов. Улмаар 2005 оны “Японы эсрэг жагсаал”-тай холбож үзвэл Ши Инь Хан мэтийн үзэл бодолтой хүн маш цөөн байгаа бөгөөд харин ч ард түмний дунд Жан Юүн Жуан мэт хатуу үзэл бодолтой хүмүүс дийлэнх хувийг эзэлж байгаа бололтой байна. Илтгэгч миний хувьд эдгээр маргааны талаар юуны өмнө дараах дүгнэлтүүдийг гаргаж болмоор санагдана.

Нэгдүгээрт, Японтой харилцах харилцааны талаар түүхийн асуудлыг өнөөг хүртэл чухалчилж буй бүлэг хүмүүс, эсвэл уг асуудалд авталгүйгээр Зүүн Азийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд Японтой харилцаагаа сайжруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж буй бүлэг, аль эсвэл Японы оролцоогүйгээр Америк болон Азийн харилцааг хөгжүүлэх нь стратегийн хувьд зөв гэж үзэж буй бүлэг гэх мэтээр хэд хэдэн бүлэгт ангилж болно. Өөрөөр хэлбэл Японы талаарх олон нийтийн үзэл бодол олон талт шинж чанартай болсоныг харуулж байна.

Хоёрдугаарт, Ши-гийн өгүүлэл нь түүхэн ач холбогдолтой хэдий ч Японыг зөвхөн Америктай явуулж буй бодлогын хүрээн дотор багтааж ойлгож байгаа нь санаа зовоож байна. Учир нь Япон, Хятадын харилцаа нь дэлхий нийтийн глобал шинж чанартай стратегийн асуудлаар хамтран хэлэлцэх, эсвэл зөвхөн хоёр орны хоорондын болон ард түмний хоорондын асуудлаас өөр асуудал хэлэлцэж чадахгүй гэсэн хоёр талтай байгаа учраас тэр юм.

Гуравдугаарт, маргааны агуулга нь сонирхол татаж байгаа хэдий ч хамгийн чухал нь дайн дууссанаас хойш хагас зуун жилийн дараа сая эрдэмтэд судлаачдын хүрээнд улмаар залуучуудын дунд интернэтээр дамжин Японыг тойрсон асуудлаар чөлөөт маргаан явагдах болсон явдал юм. Хятадын их гүрэн болох гэсэн өөртөө итгэх итгэл, зарим нэг сэхээтнүүдийн дунд “Японы асуудал цагийн аясаар мартагдах” хандлага бий болсон мэт бодогдож байна. Нөгөө талаас энэ хавар болсон Японы эсрэг жагсаалаас тодорхой харагдсанчлан Японы талаар гадны юм, гадны үзлийг эсэргүүцсэн үндсэрхэг үзэл ч мөн чөлөөтэй боллоо.

Харин Япон-Америкийн харилцаа болон эдийн засгийн хөгжилд тулгуурлан хөгжиж ирсэн Японд шинэ үзэл бодол бий юу? Японы Засгийн газрын хүрээнд ч гэсэн аюулыг мэдэрч байгаа нь тодорхой. 2002 оны 11-р сард Ерөнхий сайд Коизумигийн зөвлөх байгууллага болох Гадаад харилцааны шинжээчдийн ажлын хэсэг (Task force) нь “21-р зууны Японы гадаад бодлогын үндсэн стратеги: шинэ үе, шинэ зорилт, шинэ гадаад бодлого” гэсэн баримт бичгийг гаргав. Энэ баримт бичгийн оршилд “Өнөөг хүртэл Японы гадаад бодлого төрийн тодорхой стратегийг үйгээр явж ирсэн. Дэлхий дахин хүйтэн дайны байдалтай байсан тэр үед Америкийн хүчээр аюулгүй байдлаа сахин хамгаалуулсанаар эдийн засгийн хөгжлөө хангаж ирсэн Японы хувьд тодорхой стратеги тийм ч шаардлагатай биш байлаа. Гэтэл тэр цаг үе одоо нэгэнт өөрчлөгдсөн” гэж дурдаад “Аюулгүй байдлын асуудлыг чухалчлан Америктай харьцах харилцаагаа иж бүрнээр дахин хянаж үзэх цаг болсон”, улмаар “Хятадтай хэрхэн харьцах нь 21-р зууны эхэн үеийн Японы гадаад харилцааны хамгийн чухал сэдэв мөн” гэж тэмдэглээд хоёр орны хооронд хамтран ажиллах, харилцан оршин тогтнох, харилцан өрсөлдөөн, зөрчилдөөнүүд зэрэгцэн орших болно гэж тодорхойлсон байна. Мөн “түүхийн хүлээсээс” гарч, ирээдүй рүү чиглэсэн харилцааг бий болгох нь чухал хэмээн дурьджээ. (Коизуми. Гадаад харилцааны шинжээчдийн ажлын хэсэг 2002.11.28. “21-р зууны Японы гадаад бодлогын үндсэн стратеги- шинэ үе, шинэ үзэл бодол, шинэ гадаад бодлого”. Ажлын хэсгийн удирдагч нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын зөвлөх Окамото Юкио, Зүүн Азийн бодлогын талаар Ононоги Масао/Кейо гижюку их сургуулийн профессор/, Танино/Хятад сууж байсан элчин сайд/ зэрэг хүмүүс ажлын хэсэгт орсон байна. <http://www.kantei.go.jp/jp/kakugikettei/2002/1128tf.html>).

Хятадын талаар баримтлах стратеги нь тодорхойгүй хэвээр байсаар 2002 оноос эхлэн Япон улс “Японы Хятадтай явуулах дипломат бодлогын үнэнч түнш, Хятадтай харьцах бодлогыг тэнцвэржүүлэгч” (Гадаад харилцааны ажлын хэсгийн тайлан) гэж үзэн ASEAN-тай харилцах харилцааг идэвхжүүлэв. 1-р сард Ерөнхий сайд Коизуми Сингапурт айлчлахдаа Япон, ASEAN хоёр бол “хамт алхаж, хамт урагшлах түнш” хэмээн тодорхойлж, Зүүн Азийг “хамт алхах

нийгэмлэг” болгохын тулд Япон-ASEAN-ы эдийн засгийн нэгдмэл үзэл санаа, Зүүн Азийн Хөгжлийн Санаачлага (IDEA)-г дэвшүүлэв.

2003 онд Хятад, ASEAN-ны хооронд байгуулагдсан чөлөөт худалдааны гэрээ (FTA) болон Зүүн Өмнөд Азийн найрамдал хамтын ажиллагааны гэрээнд нэгдэн орсон зэрэг Хятадын идэвхтэй алхмуудаас үүдэн тэр оны эцэст Япон дээрх гэрээнд нэгдэн орохоо мэдэгдэж улмаар ASEAN-ы гишүүн 10 оронтой “нийтлэг журам, зарчмыг хүндэтгэн, баялаг шинэлэг эрч хүчтэй, харилцан ойлголцол болон Азийн уламжлал үнэ цэнийг ойлгож чадах хамтын үзэл санаатай Зүүн Азийн нийгэмлэг байгуулах” тохиролцоонд хүрч чадав. 2004 оноос хойш ASEAN-тай харилцах харилцаа болон “Зүүн Азийн хамтын нийгэмлэгийн” талаар Япон, Хятадын хооронд санаачлагийг хэн нь гартаа авах талаар өрсөлдөөн ч гарах боллоо.

Хэдий тийм боловч Японы хувьд “Зүүн Азийн нийгэмлэг”-ийн үзэл санаа болон “21-р зууны Японы гадаад бодлогын үндсэн стратеги”-д Америктай харилцах харилцаа, Зүүн Азийн орнуудтай харилцах харилцаа, Хятадтай харилцах харилцааг зангидах бодлого, өөрөөр хэлбэл нэгдсэн стратеги дутагдаж байна.

Зүүн Азийн нийгэмлэгийн субъект болон хөдөлгөх гол хүч нь юу байх, тэдгээр нь тухайн бүс нутгийн улс оронд чухам ямар ашиг өгөх, гишүүн орнуудын нийтлэг эрх ашиг нь юунд чиглэгдэх зэргийг тодруулах хэрэгтэй юм. Тэгэхийн тулд Хятадтай харьцах стратегийг яаралтай боловсруулах хэрэгтэй байна.

4. Өрсөлдөгч харилцааны илрэл

2005 оны хавар Хятадын томоохон хотуудад болсон “Японы эсрэг жагсаал” болон түүний дараах Япон, Хятадын хоорондын мөргөлдөөн нь Япон Хятадын харилцаанд холбоотой байдаг хэн бүхэнд томоохон цохилт болов. Нэгдүгээрт, интернет өргөнөөр нэвтэрсэн болон Төв Засгийн газрын хяналт сул байсан зэрэг шалтгаанууд байсан хэдий ч “Япон барааг худалдаж авахаа больё!” зэрэг лоозонгоор илэрсэн хэт үндсэрхэг үзэл нь нийгмийн олон талт өөрчлөлт явагдаж буй өнөөгийн Хятадад ч гэсэн урьдын адил хүчтэй нягтралыг бий болгодогыг тодорхой харуулав.

Нөгөөтэйгүүр, энэ удаагийн Японы эсрэг жагсаал нь Японыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болохыг эсэргүүцсэн бас нэгэн уриан дор явагдсан бөгөөд тэр ч бүү хэл Хятадын засгийн газар тэрхүү жагсаалын уриаг ашиглан энэ талаарх Японы эсрэг байр сууриа тодорхой илэрхийлж дэлхий нийтэд хүчтэй үйл ажиллагаа явууллаа. Энэ нь Япон, Хятадын харилцааны уг үндсэнд түүхийн асуудал оршсоор байгаа тэр үед дэлхий нийтийн болон бүс нутгийн тавцанд Япон, Хятад хоёр өрсөлдөгчийн харилцаанд орсныг харуулж байгаа бөгөөд тэр утгаараа Япон Хятадын харилцаа бас нэгэн шинэ үе шатанд орсныг гэрчилж байгаа юм.

図2-中国の対日イメージ ①

調査機関 社会科学院日本研究所、調査時点 2004.9-10、質問
家 3300人、有効回答 2987人、[日本学刊(2004年第6期)]




Diagram 2-2005 оны 3-р сар Япон, Хятад, Өмнөд Солонгосын санал асуулга ③ (Asia шимбур 2005. 4. 27)

日韓中 諸外国への見方

■ 経済的に重要な国は...





Diagram 2-2005 оны 3-р сар Япон, Хятад, Өмнөд Солонгосын санал асуулга ②



Энэ удаагийн Японы эсрэг жагсаалын цаана Япон, Хятадын хооронд чухам ямар асуудал, ямар хүчин зүйл байсныг ялгаж салгахад нэн хэцүү. Диаграмм 2-т үзүүлсэн хоёр удаагийн санал асуулгын дүн 2004 оноос Хятад болон Өмнөд Солонгос дахь Японы талаарх олон нийтийн санал бодол маш хурцалдсаныг харуулж байна. Түүнээс гадна дараах асуудлууд холилдон гарч ирсэн нь Япон, Хятадын харилцааг улам хурцатгаж байгааг юуны өмнө тэмдэглэн хэлэх хэрэгтэй.

1. Ерөнхий сайд Коизүми Ясукуни сүмд албан ёсны мөргөл үйлдэж, улмаар “шинэ түүхийн сурах бичиг”-ийг тойрсон түүхийн асуудал.

2. Тайваний “тусгаар тогтнолын” асуудалтай холбоотойгоор Японы талаарх Хятадын сэрэмжлэл. Ялангуяа 1996 оны Япон Америкийн аюулгүй байдлын гэрээг дахин тодорхойлсоноор эхэлж, 2005 оны 2-р сард Япон Америкийн аюулгүйн Гэрээний асуудлыг хэлэлцэх Хамтарсан Зөвлөл хамтын стратегийн нийтлэг зорилгодоо “Тайваний хойгийн асуудлыг яриа хэлэлцээний аргаар эв зүйгээр шийдэхийг дэмжинэ” гэсэн заалтыг оруулсан явдал Хятадын үл итгэх байдал болон шүүмжлэлийг ихэсгэв.

3. Японы НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болохтой холбогдсон асуудал. Дайнаас хойш 60 жил өнгөрч, энэ хугацаанд Япон улс энх тайвныг эрхэмлэж, эдийн засгийн хөгжлөөрөө олон улсын хэмжээнд үлэмж хувь нэмэр оруулж ирсэнээрээ бахархадаг. Дайнд ялагдсан орноос “эгэл жирийн орон” болохыг эрмэлзэж байгаа билээ. Харин Хятад өнгөрсөн түүхийн буруугаа бүрэн хүлээхгүй байна гэсэн

шалтгаанаар Японы “эгэл жирийн орон” болох тэр замд нь саад болж байна. Энэ асуудлын цаана нь Зүүн Ази болон олон улсын тавцан дээрх Япон, Хятадын хоорондын хүчний тэмцэл байгаа юм.

4. Сэнкакү бүлэг арал (Хятадаар Diaoyu Dao арал гэдэг) болон Өмнөд Хятадын тэнгисийн арлуудыг тойрсон газар нутгийн асуудал.

Япон, Хятадын харилцаа бидний хүсч байгаа шиг өөдрөг биш байгаа нь нэгдүгээрт, орон зай цаг хугацааны хувьд ялгаатай дээрх асуудлууд нь хоорондоо хутгалдаж ээдрээтэй болсон явдал юм. Ээрсэн утасны ээдрээг гаргах нь тийм ч амар зүйл биш. Хоёрдугаарт, дайнаас хойш 60 жилд бүхэл бүтэн үе солигдож, Японы удирдагчид болон олон нийтийн ихэнх нь дайны дараах байдал дууссана Тухайлбал, 1995 оны Ерөнхий сайд Мураяма-гийн уучлалт гуйсан тухай ярилцлага яг эж үзэж байхад, Хятадын удирдагчид болон олон нийт “дайны дараах байдал дуусаагүй”, Японы талаарх үзэл бодлоо илэрхийлэх нь сүүлийн үед чөлөөтэй болсноор “дайны дараагаар шийдэх ёстой асуудлууд одоо эхэлж байна” гэж үзэж байгаа зэргээс үзвэл хоёр талын хооронд гүнзгий үзэл бодлын ялгаа (perception gap) байгааг харуулж байна.

Дээр өгүүлсэн хоёр дахь онцлог бол доор өгүүлсний дагуу хоёр талын хэт туйлширсан бөгөөд явцуурхсан үндсэрхэг үзэл болон илэрч байгаа бөгөөд энэ оны хавраас хойш хоёр орны хооронд мөргөлдөөн улам гүнзгийрэх хандлагатай байна.

5. Үндсэрхэг үзлийн тоглоом

Японы залуу хятад судлаач Сонода-гийн (Васэда Их сургууль) тэмдэглэснээр “энэ удаагийн Японы эсрэг жагсаалаас харахад интернет болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл их нэвтэрснээс буюу мэдээллийн эрин зуунд шилжсэн нь Япон, Хятадын аль алинд нь үндсэрхэг үзлийн их давалгааг авчирсан. (Үндсэрхэг үзлийн тоглоомоос гаръя. “Сэкай” сэтгүүл 2005 оны 7-р сарын дугаар). Гэвч энэхүү явцуу үндсэрхэг үзэл нь Япон Хятад хоёр орны аль алинд нь үндэс бөхтэй оршиж байгаа нь асуудлыг улам ярвигтай болгож байгаа юм.

1990-ээд оны сүүлийн хагасаас хэт туйлширсан үндсэрхэг үзэл нь Хятадын соёлын нэгэн жигүүр болон хүчээ авсан. “Үгүй гэж хэлж чаддаг болсон Хятад” (1996 он) хэмээх ном гарсан нь түүний эхлэлийг тавьсан юм. Залуучуудын дунд нэрд гарч буй онолч Wang Xiaodong үндэсний болон улс хоорондын “оршин тогтнох орон зай”-наас дэлхий дахин болон Хятадын ирээдүйн хөгжлийг тодорхойлжээ.

Түүний хэлснээр улс хоорондын дунд “ээгнэх” орон зай байдаг ба улс хоорондын харилцаа нь “орших уу эс орших уу”-н төлөөх “ээгнэх” харилцаа юм. Хүч бол түүнд хүрэх цорын ганц зам мөн. “Ээгнэх” дайнд амьд үлдэхийн тулд хатуу дайчин сэтгэлтэй байх хэрэгтэй бөгөөд энэ нь зайлшгүй байх нөхцөл гэж тэр хэлжээ. Энэ нь

Америк дахь неоколонизм (neo-colonialism)-ийг түрж гарч ирсэн неореализмийн гол зарчим мөн бөгөөд Хятад тэднийг “ууртай залуучууд” хэмээн нэрлэж байна. (Wang Xiaodong. Өнөөгийн Хятадын үндэсний үзлийн онол, Даяаршлын хар үүлэн доорх Хятадын зам).

Хятадын нэгэн онолчийн үзэж буйгаар өнөөгийн Хятадын үндсэрхэг үзэл нь ихээхэн сэтгэл хөдлөлийн шинжтэй байгаа бөгөөд түүний гол шалтгаан нь сүүлийн зуун жилд “доромжлолын түүх”-ийг туулж ирсэн хохирогчийн сэтгэхүй дээр даяаршилд хоцорч орж ирсэнээр бүхнийг даяаршлын хэм хэмжээнд нийцүүлэхийн тулд төрөл бүрийн дарамт хохирол амсч байна гэсэн хохирогчийн ойлголт гүнзгий байна гэжээ. “Хятадын бахархалыг гутаасан” хэмээн Макдональдсын сурталчилгааг зогсоосон (Асахи шимбун /Асахи сонин/ 2005 оны 6-р сарын 24-ний өдрийн дугаар) нь мөн үндсэрхэг үзлийн нэгэн илрэл юм. (Энэ тухай Le Shan. Нуугдмал хандлага: Явцуу үндэсний үзлийн талаарх шүүмжлэл болон бодрол. Багшийн их сургуулийн хэвлэлийн газар. 2004) International Herald Leader “2004.11.9 дугаарыг үзнэ үү)

Нөгөө талаас Японд ч мөн үндсэрхэг үзэл дахин сэргэж байна. 1950-1960-аад онд дайны өмнөх Японы үнэ цэнэтэй гэсэн бүхэн үгүйсгэгдэж, дайны өмнөх үнэ цэнэт зүйлсэд “Японы гарал үүсэл”-ийг олж илрүүлж чадах үндэсний үзэлтэй хүмүүс маш цөөн байсан бөгөөд тэд нийгмийн үндсэн хэсэг болж чадаагүй. Гэвч дээр өгүүлсэнчлэн дайнаас хойш 50 жил өнгөрснөөр Японы удирдагчид болон олон нийт “дайны дараах үе дууссан” гэж ойлгосон. Тэр нь ч ард түмний нэгдмэл ойлголт байсан гэж бодож байна. Гэтэл 1950-1960 онд цөөнх болж байсан тэр хэсэг одоо “доромжлогдсон 50 жил”-ийг сэргээх, хуучин үндэсний үзэлд тулгуурлан дайныг дахин цэгнэх, дайны дараах үеийг дахин үнэлэхийг оролдож байна.

Коизумигийн засгийн газар засгийн эрхэнд гарсан нь үүний тодорхой илрэл юм. Азийг эзлэн түрэмгийлсэндээ гэмшсэн хуучныг баримтлагч улс төрчдийн ихэнх нь улс төрийн тавцангаас буулгаасан. Өнөөгийн дөч, тавьтай улс төрчид Азийн улс орнуудтай хийсэн дайны түүхийг бараг мэдэхгүй бөгөөд өмнөх үеэсээ илүү барууны үзэлд автагдсан. Ийнхүү хуучин шинийн ялгаа улам бүр ихэсч байна.

Ерөнхий сайд Коизумигийн Ясукуни сүмд мөргөл үйлдэхийг дэмжиж буй олон улс төрчид бий бөгөөд мөн олон нийтийн бараг тэн хагас нь үүнийг дэмжиж байгаа нь өнөөгийн японы үнэн дүр төрх юм. “Алс Дорнодын олон улсын цэргийн шүүх хурал бол энх тайван хүмүүнлэгийн эсрэг гэмт үйлдэл хэмээн холбоотны цэргийн тулгасан нэг талыг баримталсан шүүх байсан. ...А зэрэглэлийн цэргийн гэмт хэрэгтнүүд бол нэгэнт гэм буруугүй” гэх мэт утга учиргүй үг засгийн газрын өндөр албан тушаалтны амнаас сонсогдох болсон нь (Эрүүл

мэнд, хөдөлмөрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Мориока-гийн 5-р сарын 26-ны өдөр хэлсэн үг) дээрх байдлыг гэрчилж байна.

Ийнхүү Япон, Хятадын аль алинд нь хэт үндсэрхэг үзэл өргөжиж байгаа ийм нөхцөлд Япон, Хятадын хооронд тогтвортой болон бүтээлч харилцааг бий болгох нь тийм ч хялбар биш гэдэг нь тодорхой.

6. Япон, Хятадын харилцааг хэрхэн дахин бүтээн босгох вэ?

Сүүлийн арван жилийн Япон, Хятадын харилцаа нь дипломат харилцаа сэргээснээс хойш хоёр орон хоёул бие биеийн талаар баримталж ирсэн хоёрдмол стандартын бодлого нь нуран унасныг харуулж байна.

Хятад улс 50-иад оны сүүлийн хагасаас хойш Японтой харьцахдаа зарим нэг хуучинсаг үзэлтнүүд, хэт барууныг баримтлагчид болон “милитаристуудад” хатуу ширүүн хандаж, нөгөө талаар японы ард түмэнтэй ойртон нягтарч зөөлөн харьцах гэсэн хоёрдмол стандартын бодлого баримталж ирсэн. 1972 онд Японоос Хятадад төлөх дайны төлбөрийг хүчингүй болгосон шалтгааны нэг нь “японы ард түмэнтэй байгуулсан найрамдалт харилцааг” бодолцсонтой холбоотой болов уу. Хэдий тийм боловч энэхүү хоёрдмол стандарт нь Япон дахь өөрчлөлт болон Хятадад хийсэн Японы түрэмгийллийг уучлахгүй байгаа олон нийтийн үзэл бодлын дүнд улам бүр утгаа алдсаар байна.

Нөгөө талаас Япон улс эзлэн түрэмгийлсэн дайн дэгдээсэндээ гадаадын улс орнуудад хандаж буруугаа хүлээж уучлалт гуйсан боловч дотооддоо дайны хариуцлагын асуудлыг үндсэнд нь шийдэж чадсангүй. Харин ч дайныг тэр чигээр нь үгүйсгэхгүй байдал үргэлжлэв. А зэрэглэлийн цэргийн гэмт хэрэгтнийг Ясукуни сүмд хамт тахиx, ерөнхий сайдын тус сүмд мөргөл үйлдсэн зэрэг нь үүний тод илрэл юм. Өөрөөр хэлбэл гадаад дахинд болон дотоодод гэж ялгаж хуваасан хоёрдмол стандартыг Япон улс бас мөрдөж ирсэн хэрэг. Улмаар дээр дурьдсанчлан дайнаас хойш тавин жил болмогц нуугдмал байсан үндсэрхэг үзэл нээлттэй болон гарч ирж, тэр ч бүү хэл гадаад орнуудтай харьцах харьцаанд ч илрэх болсоноор хоёр орны харьцаан дахь хоёрдмол стандартын үе дуусгавар болов.

Өөрөөр хэлбэл Япон, Хятадын харилцаа цоо шинэ үе шатанд гарлаа. Хятадын их гүрэн болох, Японы улс төрийн хувьд их гүрэн болох гэсэн бодит байдал, дээр өгүүлсэн хоёр орны дотоод байдал энэ бүхнийг уялдуулан хоёр орны харилцааг шинээр зохиох шаардлага гарч ирж байна. Үүний тулд юуны өмнө дараах арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй болов уу.

1. Япон, Хятадын харилцааг оновчтой тодорхой болгох. Үүнд хоёр орны удирдагчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг их чухал.

2. Хоёр орны хоорондын болон бусад орнуудын төрийн тэргүүнүүдийн айлчлалыг тогтмолжуулах. Тухайлбал олон талт орнуудын

айлчлалын хүрээнд 2005 оны сүүлээр болох Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт найдвар төрүүлж байна.

3. Эдийн засгийн зөрчилдөөн, газар нутгийн болон далай доорх баялгийн маргаан, аюулгүй байдал, түүхийн асуудал, Зүүн Азийн хамтын нөхөрлөлийг тойрсон асуудлуудлаар цаашид зөрчилдөөн гарах магадлал өндөр. Нэг хүрээний зөрчилдөөн маргааныг нөгөө рүү халдаахгүйн тулд тухайн асуудал, түвшингээр харилцааны хүчтэй сувгийг бий болгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл аюулыг зохицуулах механизмийг бий болгох хэрэгтэй.

4. Түүхийн асуудлын хувьд Япон, Өмнөд Солонгосын хооронд байгуулсан түүхийн асуудлыг хэлэлцэх хамтарсан комиссын үйл ажиллагааг Япон, Хятад, Өмнөд Солонгосын хүрээнд өргөжүүлж, Япон-Өмнөд Солонгос болон Япон-Хятадын хооронд түүхийн талаарх харилцан ойлголцол, нэгдмэл ойлголтыг бий болгохын тулд Япон, Хятад, Өмнөд Солонгос 3 улсын түүхийн асуудлаарх хамтарсан комиссыг байгуулах. Үүнд гуравдагч орны оролцоо ч байж болох юм. “Түүхийн асуудлыг хамтарсан зөвлөлд бүрэн хариуцуулна” гэсэн талуудын шийдвэр хамгийн чухал.

5. Япон, Хятадын хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх. Байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх болон харилцан туслалцах, эрчим хүчний нөөцийн байгууллагыг байгуулах зэрэг асуудлаар хамтарсан төслийг хэрэгжүүлж эхлэх нь илүү дөхөмтэй.

6. Зүүн Азийн чөлөөт худалдааны гэрээ, Зүүн Азийн хамтын нийгэмлэг зэрэг бүс нутгийн хэмжээний хамтын ажиллагааны байгууллага болон бүтцийг бий болгох нь үзэл санааны хувьд хэврэг, бүтцийн хувьд ч тогтвортой бус байгаа Япон, Хятадын харилцааг бэхжүүлж, улмаар хоёр орны харилцааг шинээр бүтээн босгоход чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна.

7. Ирээдүйд удаан хугацааны турш Япон, Хятадын харилцааг гардан явуулах хүмүүс хоорондын хэлхээ холбоог бий болгох нь зайлшгүй хэрэгтэй. Үүний тулд залуу улс төрч, сэтгүүлч, эдийн засагч, онолч, шүүмжлэгчдийг бэлдэх “Зүүн Азийн Аспирантурын Их Сургууль” мэтийн өндөр дээд боловсролын байгууллагыг хамтран байгуулж, Японы болон Хятадын хоёр талын мэдлэгтэй сэхээтнүүдийг бэлдэх хэрэгтэй байна.

Дээрх арга хэмжээнүүд нь учирч болох нөхцөл байдал зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлж, тэдгээрийг хянах хамгийн наад захын арга хэмжээ юм.

Япон хэлнээс орчуулсан М.Нарантуяа, Васэда их сургуулийн докторант Л.Лхагвасүрэн